



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/252

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын 2.1.4, 3.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 25 дугаар захирамжаар зохион байгуулагдаж байгаа Монголын багш нарын VII их хуралд оролцох 20 төлөөлөгчийн унааны зардалд зориулж 2 600 000 төгрөгийг зарцуулсугай.

2.Зардалд зарцуулагдах 2 600 000 төгрөг /Хоёр сая зургаан зуун мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ